

**ШАШНЫ НИЙГМИЙН ҮҮРГИЙН ТАЛААРХ СУРАГЧДЫН МЭДЛЭГ,
УР ЧАДВАР, ХАНДЛАГЫГ САЙЖРУУЛАХ НЬ.
СУРГАЛТЫН АРГА: АСУУДАЛД СУУРИЛСАН АРГА ЗҮЙН
ЖИШЭЭН ДЭЭР**

*Б. Болормаа
Доктор (Ph. D.)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

bumbaalai8888mn@yahoo.com

*Г. Домбормаа
Магистрант*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Нээлттэй боловсролын төв*

Doogii0011@gmail.com

Хураангуй: Өнөө цагийн нийгмийн харилцаанд шашин, шүтлэгийн сайн, муу тал зэрэгцэн оршин байгаа бөгөөд дэлхийн соёл, эдийн засаг, нийгмийн сүлжээ хурдтай даяаршиж байгаа энэ үед шашины муу үр нөлөө хурдтай түгэн дэлгэрч, өсвөр насны залуусын ертөнцийг үзэх үзэлд хортойгоор нөлөөлж байна. Тиймээс энэхүү судалгаанд түүхийн хичээлийн сургалтын арга зүй, үр дүнг сайжруулах замаар шашин шүтлэгийн сөрөг нөлөөллөөс өөрийгөө хамгаалах мэдлэг, ур чадвар, хандлагыг өсвөр насны хүүхдүүдэд төлөвшүүлэх боломжийг судлах зорилго тавин ажилласан. Судалгааны зорилгоо биелүүлэхдээ эхний үе шатанд чанарын судалгааны феноменологийн аргад түшиглэн түүхийн хичээлийг заах олон улсын шилдэг туршлагауудын тухай Англи, Солонгос хэл дээрх 50 гаруй судалгаанд суурилсан эх сурвалжаас өгөгдөл, мэдээлэл, нотолгоог цуглуулах, дүн шинжилгээ хийн судалгааны ажлыг зохион байгуулсан. Судалгааны ажлын явцад иргэний боловсролоор дамжуулан нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхдээ асуудалд суурилсан суралцахуйн аргаар түүхийн хичээлийн сургалтын үр нөлөөг дээшлүүлсэн БНСУ-ын судлаачид Паг Сон Ми, Кан Ин Э, Ким Хан Жун, Жви Санг Хун, Жви Жонг Им, Ю Жи Ён нарын туршилтууд нь үр дүн өндөртэй, Монгол Улсын ЕБС-ийн сургуулийн сургалтын онцлогт тохируулан нутагшуулахад илүү үр өгөөжтэй болох нь ажиглагдсан. Судалгааны ажлын үр дүнд уг Солонгосын судлаачдын туршлагад түшиглэн асуудалд суурилсан суралцахуйн сургалтын аргаар Монголын түүхийн хичээлийг заах жишиг загварыг шашин шүтлэгийн нийгмийн үүрэг сэдвээр боловсруулж гаргасан.

Түлхүүр үгс: Түүхийн сэтгэлгээ, судалгааны арга зүй, гаж урсгал, мэдлэг чадвар, хандлага төлөвшил, иргэний боловсрол, хичээлийн төлөвлөгөө

УДИРТГАЛ

Хүн төрөлхтөн үүссэн үеэс л салшгүй холбоотой байж,

хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл санаа, оюун бодол, соёлын хандлагад нөлөөлж ирсэн нэг

чухал үзэгдэл бол шашин шүтлэг гэдэгт хэн ч маргахгүй байх. Шашин нь хүн төрөлхтний түүхэнд янз бүрийн үүрэг гүйцэтгэж байжээ. Шашин хүн төрөлхтний мэдлэгийн эх сурвалж болж, соён гэгээрүүлэх, ёс суртахууныг түгээн дэлгэрүүлэх, соёл урлаг, анагаах ухааныг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн байдаг. Гэхдээ шашны хөгжил хөдөлгөөнгүй, туйлширсан, хатуу үзэл санаа нь шинжлэх ухааны хөгжилд саад тушаа болж, харанхуй бүдүүлэг, мухар сүсэг бишрэл түгээн дэлгэрүүлж, хүний хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байсан нь мундахгүй их билээ. Шашин улс төрийн асуудалд гүнзгий оролцох болж, шашны лам нар эрх баригч ангийн төлөөлөл болж, улмаар шашны явцуу сонирхлоос үүдэн олон улс үндэстэнг хамарсан дайн тулаан гарч байсан түүх одоо хүртэл үргэлжилсээр байна. Хүн төрөлхтөн төр, шашин хоёрыг салгаж байж хөгжлийн зөв зам руу орсон түүх байдаг. Үүнийг бид сэргэн мандалтын үе гэж нэрлэдэг билээ.

XVIII зууны сүүл үеэс эхлээд Европ тивд тэр тусмаа Англи, Франц, Итали, Герман, Шотланд гэх баруун Европын улс орнуудад хүний эрх чөлөөг дээдэлсэн либерал үзэл, капиталист эдийн засаг түгэн дэлгэрч, хувийн хэвшил хөгжиж, үйлдвэрийн эзэн гэсэн шинэ эрх баригч анги гарч ирээд язгууртнууд, шашны эрх мэдэлтнүүдийн улс төр, эдийн

засгийн байр суурийг бууруулжээ. Энэ үеэс хойш шашны эдийн засаг, улс төр дахь нөлөө ихээхэн суларсан ч, шинэ зууны эдүгээ үед шашны нийгэм, хүмүүст үзүүлэх нөлөө, ач холбогдол хүчтэй хэвээр байна. Өнөө цагийн нийгмийн харилцаанд ч гэсэн шашны сайн, муу тал зэрэгцэн оршиж байна. Хүмүүнлэг, энэрэнгүй үзэл санааг нийгэмд түгээх, нийгмийн эсрэг зан үйл, ёс суртахуунтай хүмүүсийг нийгэмшихэд туслалцаа үзүүлэх, орон гэргүй хүмүүст туслах, ядуусыг тэтгэх буяны үйл ажиллагаа явуулах зэрэг зөв хандлага, үйл ажиллагааны олон жишээ бий. Гэхдээ шашны хэт туйлширсан үзэл санааг даган мөрдсөнөөс болж шашин хоорондын зөрчил үүсэх, хүний сэтгэн бодох эрх чөлөөг үгүйсгэх, шашны үзэл санааг хүчээр тулгах, бага насны төлөвшөөгүй хүүхдүүдэд мухар сүсгийг түгээх, итгэл бишрэлийг бизнес гэж харах үзэгдэл түгээмэл болжээ. Хамгийн ноцтой нь соёл, эдийн засаг даяаршихын хэрээр, мэдээлэл холбооны технологийн хөгжлийн нөлөөгөөр хил хязгааргүй мэдээллийн ертөнц бий болсон энэ үед шашны сайн, муу үр нөлөө нь хоёулаа хурдтай даяаршиж байна. Хамгийн сүүлийн жишээ бол БНСУ-ын улсын Тэгү хотод КОВИД 19 вирусийн тархалт огцом гарч, тус улсыг бүхэлд нь хамарсан өвчний тархалт бий болоход шашны бүлэглэлийн буруутай үйл ажиллагаа нөлөөлсөн. Солонгос

улсад Корона вирусээр халдвар авсан иргэдийн 70-аас дээш хувь нь Тэгү хотоос илэрч, тэр дундаа Шинчонжи хэмээх шашны гаж урсгалын итгэгчид олонх болох нь тодорхой боллоо. БНСУ-ыг түгшүүрт автуулж байгаа гол асуудал нь 1000 хүн нэг танхимд цугларсан тус шашны сүмийн уулзалтад Корона вирусийн халдвартай хүн 2 ч удаа очиж оролцсон нь тус улсын нийгмийг айдастай болгох гол нөхцөл болсон байна.

Ийм үед шинэ зуунд шашны нийгмийн үүргийг юу гэж харах вэ? Шашны сөрөг үүрэг нөлөөг хэрхэн бууруулах вэ гэдэг асуултууд бидний өмнө гарч байна. Монгол орны хувьд ч шашны нийгэмд үзүүлэх нөлөөний талаар төр засаг анхаарал хандуулах ёстой, олон нийтийн санаа зовоосон олон асуудал байна.

1990-ээд оноос шашны олон чиглэл урсгал эрчимтэй үйл ажиллагаа явуулж, сүм хийд олноор байгуулагдлаа. Монголчуудын шашин шүтэх эрх чөлөө, олон шашинаар дамжуулж бусад орны түүх соёлын сэтгэлгээг танин мэдэх боломж нээгдлээ. Гэвч Монголд буддын шашны хэт гажуудсан, мухар сүсэг бүхий чиглэл урсгал нь түгэн дэлгэрлээ. Лам нар бусдыг харааж ерөөж, хувь заяаг нь төлөгдөж өргөл барьцаар засаж залруулна. Хулгай хийсэн, хүн айлгаж ичээсэн, мөнгө төгрөг

луйвардсан этгээдүүд луйврын мөнгөөрөө нүглээ цайруулах болов. Лам нар баяжин үнэтэй машин унан тансаглаж, шашины сургаалиа зөрчин эхнэр авч, хүүхэнтэй зугаалж, орой үдшийн цагаар пиво, архи зооглоцгооно. Шашины тухай ийм л ойлголттой болов. Дээрээс нь бөө мөргөлөөс тодрон гарч тэнгэр сахиустай блогчдын цуваа хөвөрнө. Онгод дуудаж бөө болоод дараа нь бурхны ном сургаал, тарни шившлэгээр зам мөрийг нь засаж суух. Шашны сургаал хэрхэн гажууддагийн сонгодог жишээг Монголоос харж болно.

Тухайлбал Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэ зуу” хийдийн тахилч лам ажилтай Н.Г. голч лам Э.Д. хийдийн их гэхсүй лам Б.Ж. нарын 2015 оны есдүгээр сарын 15-нд хамт архи уусан 19 настай эмэгтэйг хүчиндсэн хэрэг,¹⁶ Сонгино хайрхан дүүргийн долдугаар хорооны Дэнжийн гудамжинд 2019 оны аравдугаар сарын 7-ны өдөр олон лам нар цугларч архидан согтуурч, тус дүүргийн нутагт оршин суудаг 37 настай эрэгтэй, лам Д-г хэрцгийгээр зодож, олон удаа хутгалан хөнөөсөн хэрэг¹⁷ зэрэг лам нарын холбоотой гэмт хэрэг, ёс суртахууны алдаатай үйлдлүүд ихээр гарч байна. Мөн сүм хийдэд шавилан сууж байгаа болон үйл ажиллагаанд хамрагддаг лам нарын нэгдсэн мэдээллийн сан

¹⁶ <https://dnn.mn>

¹⁷ <https://news.mn/r/2208491/>

бүрдүүлэх, үүнд хяналт тавьдаг байх хэрэгтэй байна. Шашны боловсрол олгож буй хөтөлбөр, сургалтуудтай танилцаж, хүүхэд хамгааллын стандарт шаардлагыг мөрдүүлэх нь зүйтэй. Энэтхэг улс руу шашны чиглэлээр сурахаар явсан 1000 гаран суралцагчдын ахуй амьдрал, нийгмийн асуудалд анхаарах шаардлагатайг Балбын нийслэл Катмандуд 3 сар хоригдсон Б.Б⁹, Карнатака мужийн Уттара-Каннада тойргийн Мундгод хот дахь Төвдийн II баазын оюутны байрны ариун цэврийн өрөөнд 4 жил суралцсан монгол оюутан Б гэх 19 настай хүү амиа хорлосон¹⁰ явдал харуулсаар байна.

“Мүүнийн шашин”, “Шинэ тэнгэр, газрын сүм”, “Төгс хүчит бурхны сүм”, “Ээж бурхан”, “Еховагийн гэрчүүд” зэрэг 30 гаран гаж урсгалын (культ) сүмүүд нэлээд өргөн цар хүрээтэй далд хэлбэрээр Монголд үйл ажиллагаа явуулсаар байна. Зураг харж гэрлэх, оршуулгын газрын авсанд хэвтэх хоноглох, технологийн дэвшлийг үгүйсгэх, Монголын соёл иргэншилтэй харшлах, гишүүдээ захиргаадан дарангуйлах, айдаст автуулах, нийгмийн амьдралаас холдуулж идэвхгүй болгох, тэдний хөдөлмөрийг мөлжих, эд хөрөнгийг нь хандив болгож авах, амиа хорлоход уриалах, гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олон, нийгмийн хүрээллээс нь хөндийрүүлж, ажил

сургуулиас нь гаргах зэрэг сөрөг үйлдэл үзүүлсээр байна.

Манай оронд шашны сайн үр нөлөөнөөс гадна сөрөг үр нөлөө газар авч олон нийтийн санаа бодлыг түгшээх болсон энэ үед шашны сөрөг нөлөөнөөс өсвөр насны залуучуудыг яаж хамгаалах вэ гэдэг асуудал чухлаар тавигдаж байна. Тийм ч учраас энэхүү судалгаанд дунд сургуульд шашины тухай боловсролыг хэрхэн олгож байна. Шашины талаар мэдлэг олгож буй сургалтын арга нь өсвөр насны хүүхдүүдийн шашиныг харах үзэл бодол, хандлагад хэрхэн нөлөөлж байна вэ гэсэн судалгааны асуултуудыг дэвшүүлж судлахыг зорьсон.

Энэхүү судалгааны зорилгоо биелүүлэхдээ дараах хэд хэдэн зорилтуудыг дэвшүүлэн тавьсан. Нэгдүгээрт Монгол оронд шашин хөгжиж ирсэн эрт, эдүгээгийн түүхэн шалтгаан, хөгжлийн зам, одоогийн үеийнхэнд үзүүлж буй үр нөлөөний талаар судалгаа хийсэн гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачдын зохиол бүтээл өгүүлэлтэй танилцах, боловсрол судлалын талаас Монгол дахь шашины асуудлыг судлах боломжийг судлах зорилт тавьсан. Хоёрдугаарт манай орны ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр ангийн сурагчдын түүхийн хичээлийн төлөвлөгөө, хөтөлбөрт шашины сэдвүүд хир тусгагдсан, ямар сургалтын арга дээр түшиглэн

⁹ <https://www.24tsag.mn/a/7263>

¹⁰ <https://montsame.mn/mn/read/18988>

сургалт явагдаж байгаа дээр чанарын баримт бичгийн, ярилцлагын, бүлгийн ярилцлага зохион байгуулж ажиглалт хийхийг зорьж ажилласан. Гуравдугаарт түүхийн хичээлийн чанартай сургалтаар дамжуулан нийгмийн үзэгдлийг зөв тайлж, ойлгох сэтгэхүй, ур чадвар, хандлагыг өсвөр насны хүүхдүүдэд хөгжүүлэхэд хэрэглэж амжилт олсон олон улсын шилдэг туршлагауудыг судалж, манай оронд нэвтрүүлж болох сургалтын аргыг сонгож, хичээлийн жишиг загварыг боловсруулах зорилт тавьсан.

Уг судалгааны ажил нь (1) “Шашны нийгэмд үзүүлж буй үр нөлөөний тухай судалгаа”, (2) “ЕБС-ийн түүхийн хичээлийн сургалтын арга зүй, ба шашны талаарх сурагчдын мэдлэг”, (3) Түүхийн хичээлийг заах олон улсын туршлага ба шашны сэдэвт хичээлийг асуудалд суурилсан суралцахуйгаар явуулах гэсэн үндсэн 3 хэсэг, удиртгал, дүгнэлтээс бүрдэж байгаа болно.

“ШАШНЫ НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨНИЙ ТУХАЙ СУДАЛГАА

Шашин шүтлэг хүний амьдралын хэв маяг, ертөнцийг үзэх үзэл, улс төр, нийгмийн үзэл санаанд нөлөөлсөөр ирсэн. Дэлхийн хамгийн том шашин болох Христийн шашины 2.1 тэрбум шүтэн бишрэгч нарын амьдралын хэв маягийг судалсан судалгаанууд шашин эрүүл зан үйл, нийгмийн

дэмжлэг, сэтгэл зүйн төлвийг хянах замаар эрүүл амьдралын хэв маягийг хамгаалж, дэмжиж чаддаг болохыг нотолсон байдаг(Creel, 2007, Dow, 2007).

Зарим судлаачид шашин хүний бурханлаг байдалд нөлөөлөхөөс гадна хүний ёс суртахууны хөтөч, амьдралын философи болдог гэж дүгнэсэн байдаг(Эйнолф, 2011, Фармер ба бусад, 2009). Мөн шашин хүний амьдралын утга учир, зорилгод нөлөөлөөд зогсохгүй өнгөрсөн, одоо, ирээдүйг харах өнцөгт нөлөөлж энх тайван, сайн сэтгэлд нөлөөлөхийн зэрэгцээ дайн тулаан, хагарал бутралд нөлөөлдөг болох нь судалгаагаар тогтоогдсон байдаг. (Симт ба бусад., 2004).

Ихэнх судалгаа шашин шүтлэг хүний амьдралын хэв маяг, ертөнцийг үзэх үзэл санаанд нөлөөлөх замаар хүний үйл ажиллагаа, ёс суртахуун, нийгмийн эв нэгдэл, энх тайван, зөрчил, хагарал тэмцэл, дайн тулаанд хэрхэн нөлөөлж буйг судалсан байдаг. Гэхдээ өнөөгийн нийгмийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж буй шашин шүтлэгийн нөлөөг бууруулах, урьдчилан сэргийлэх, мэдлэг, зан үйл, ур чадвар хандлагыг өсвөр насны хүүхдүүдийн дунд төлөвшүүлэхэд түүхийн хичээлийн сургалтын үр дүнг сайжруулахад сургалтын арга зүйг сайжруулах судалгаа төдийлөн их хийгдээгүй байна. Тийм учраас энэхүү судалгаанд “ЕБС-д түүхийн хичээлийг заахад ямар сургалтын

арга зүй хэрэглэдэг, одоогийн арга зүй нь шашины талаарх сурагчдын мэдлэгт ямар нөлөө үзүүлж байгааг судалж, түүхийн хичээлээр дамжуулан олж авч буй сурагчдын шашны тухай мэдлэг, ур чадвар, хандлагыг сайжруулахад асуудалд суурилсан суралцахуйн аргыг ашиглах боломжийг судалсан. Ингэхдээ олон улсын туршлагыг судалж, асуудалд суурилсан суралцахуйн сургалтын аргаар түүхийн хичээлийг заах жишиг загварыг шашин нийгмийн үүрэг сэдвээр хийсэн.

“ЕБС-ИЙН ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ БА ШАШНЫ ТАЛААРХ СУРАГЧДЫН МЭДЛЭГ”

Түүхийн хичээлийн үндэсний хөтөлбөр, стандарт, агуулга

Монгол Улсын боловсролын зорилго нь “иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай иргэн болгон төлөвшүүлэхэд оршино.”¹⁵ гэж заасан байдаг.

Түүхийн хичээлийн цөм хөтөлбөрийн зорилго нь “Сурагч нь түүхэн үзэгдэл, үйл явдлыг үндэслэлтэйгээр тайлбарлах, эх сурвалж, мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргахад түүхийн үнэт зүйл, арга, сэтгэлгээгээр хандан,

бие даан бүтээлчээр суралцах мэдлэг, чадвар эзэмшинэ.”¹⁷ гэж заажээ.

Түүхийн сургалтын үр дүнд сөрөг үр нөлөө үзүүлж буй тулгамдсан асуудлууд

Одоог хүртэл Монголын ЕБС-д нэгж хичээлийн хөтөлбөр, ээлжилт хичээлийн төлөвлөлтийн нэгдсэн загвар байхгүй байна. Сургууль бүр, багш бүр өөрийн өөрийн үзэмжээрээ хийсээр байна. Тийм учраас нэгж хичээлийн хөтөлбөр, ээлжит хичээлийн төлөвлөлт хийхдээ түлхүү анхаарч, сургалтын хэрэглэгдэхүүн, орчин, сурагчидтай ажиллах арга зүйг турших, хөгжүүлэх тал дээр учир дутагдалтай байна. БНСУ-ын ЕБС-д хичээлийн хөтөлбөр төлөвлөгөө нь нэгдсэн байдаг бөгөөд багш тухайн бэлэн хөтөлбөр төлөвлөгөөнд тулгуурлан заах арга зүйгээ боловсруулж, сурагчдад аль болох хүртээмжтэй, бие дааж мэдлэг чадвар олгох хандлага төлөвшүүлдэг.

Дээр дурдсан сургалтын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд ЕБС-ийн бодит орчин, сургалтын арга барил, хэрэглэгдэхүүн, суралцагчдын амьдралын боломж бололцоо зэрэг олон асуудлаас үүдээд бүрэн хэрэгжихэд хүндрэлтэй байна. Ээлжит хичээлийн төлөвлөлтөд сурагчдад багаар, хосоор, ганцаарчилж

¹⁵ Боловсролын тухай хууль

¹⁷ “Түүхийн хичээлийн цөм хөтөлбөр” 2 дахь удаагаа сайжруулсан. 2019 он

сургалт явуулахдаа сургалтын янз бүрийн арга зүйг дурдан оруулдаг ч хичээлийн агуулга их, анги дүүргэлтийн даац хэтэрсэн, хичээлийн хэрэглэгдэхүүний хомстол, техник технологийн хүрэлцээ дутмаг зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж биеллээ олохгүй байна.

Багш төвтэй сургалтын арга барилаас шавь төвтэй сургалтын арга зүй рүү шилжсэн гэх боловч бодит байдал дээр уламжлалт аргаар сургалт явуулсаар байна. Үүнээс үүдэн сурагчид хичээлдээ сонирхолгүй болох, залхах хөндийрөх үзэгдэл гарч, сургалтын зорилго, зорилт биелэхэд хүндрэл учруулж байгаа юм.

Шашин гэж дурьдаад өнгөрөх биш түүний нийгэмд үзүүлж буй нөлөөллийн талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, харилцан санал солилцох, мэтгэлцэх, шашны эерэг болон сөрөг үзэгдлийг тайлбарлах, өөрийн үзэл баримлал, хандлагатай болоход анхаарах шаардлагатай байна.

ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙГ ЗААХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА БА ШАШНЫ СЭДЭВТ ХИЧЭЭЛИЙГ АСУУДАЛД СУУРИЛСАН СУРАЛЦАХУЙГААР ЯВУУЛАХ

Хичээлийн сургалтын чанар, үр дүнг сайжруулахын тулд олон оронд боловсролын шинэчлэл хийж, үр дүнд хүрсээр байна. 21-р зууны нийгэм бол зөвхөн өргөн

хүрээний мэдлэгийг санаж чаддаг авьяаслаг хүн биш, мэдлэгийг олж авах арга зүйг мэддэг, асуудлыг шийдвэрлэхэд ашигладаг, бусадтай хамтран ажиллах чадвартай мэргэжилтэнг хүсэх болсон. Үүнтэй уялдуулан боловсролын салбарт боловсролыг шинэчлэхтэй холбогдуулан гарч буй шинэ үзэгдэл бол сургалтын онол, боловсролын парадигм болох конструктивизм юм (Канг И-А Kang In-A, 1997). Конструктивизмын тодорхой сургах-суралцахуйн загваруудын нэг бол “асуудалд суурилсан суралцахуйн арга (Problem-Based Learning) “юм.

Пак Ин-ок (1999) асуудал дээр суурилсан сургалтын (PBL) эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд үзүүлэх нөлөөг судалсан, Жон Ду Гинг(2001) асуудалд суурилсан сургалтад ахлах сургуулийн ерөнхий нийгмийн хичээлийн жишээн дээр судалгаа хийхдээ интернэтийг өргөн ашиглаж, бүлэг хоорондын мэтгэлцээний зарчмыг хэрэглэсэн байна. Хюн-Ах Ли (2006) дунд сургуулийн түүхийн хичээлүүдэд сургалтын аргыг ашиглах замаар ангийн сэтгэл ханамж, түүхэн сэтгэлгээний чадварыг сайжруулах, асуудалд суурилсан суралцахуйн аргын үнэлгээний аргачлалын өөрчлөлтийг судалжээ. БНСУ-д түүх нийгмийн ухааны хичээл дээр асуудалд суурилсан суралцахуйн сургалтын аргыг туршиж, энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажил явагдсаны үр дүнд түүх

нийгмийн ухааны хичээлийг сонирхох сурагчдын тоо өсөж, идэвх оролцоо нэмэгдсэн байна (Пак Ин-юк, Жүн-гьон, Мён-сүнг Ли, 1999). Уг суралцахуйн арга нь эрэл хайгуул хийж мэдлэг олж авах, олж авсан мэдлэгтээ дүн шинжилгээ хийх чадварт суралцаж, түүхэн үйл явц, нийгмийн амьдралд зөв үнэлэлт дүгнэлт өгөх хандлагыг өөртөө бий болгодог сургалтын арга юм. Зөвхөн өнгөрсөн үеийг дурсах сурах бичиг биш, одоо байгаа бодит түүхийг үнэлж, тайлбарлах нь чухал бөгөөд үүнээс гадна өнгөрсөн үеийн үнэн бодит түүхээр дамжуулан өнөөгийн болон ирээдүйн төсөөллийг авах хэрэгтэй гэдэг ойлголт арга зүйг асуудалд суурилсан суралцахуйн арга эзэмшүүлдэг байна.

2011 онд Пак Ми Сонг ахлах сургуулийн Солонгосын түүхийн хичээл дээр туршилт хийсэн эрдэм шинжилгээний ажилдаа асуудалд суурилсан суралцахуйн аргын боловсруулалт, хэрэглэх зарчим, үе шат, үйл явц, сургалтанд хэрхэн хэрэглэх, сургалтад хэрэглэсэн үр дүн, ахиц зэргийг тодорхой гаргасан байна.

Тэрээр суралцахуйн зорилгыг тодорхойлохдоо танин мэдэхүй, ур чадвар, хандлага төлөвшил гэсэн үндсэн 3 хэсэгт хуваасан байна.

Жишээ нь: хүснэгт 1-д Дугду бидний газар гэсэн сэдвийн хүрээнд суралцахуйн зорилгыг тодорхойлсон байна. Багшийн зүгээс Асуудалд суурилсан

суралцахуйн аргаар сонирхолтой сэдэлжүүлэлт гаргаж өгснийг хүснэгт 1-ээс харж болно.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилго

Танин мэдэх	<ul style="list-style-type: none"> - Японы түүхийн сурах бичгийн гажуудлыг мэдэх - Японы Дугдугийн асуудлын талаар бидний байр суурийг мэдэх - Дугду Солонгосын газар нутаг болохыг баримтаар нотлох
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> - Дугдугийн талаар баримталж буй Японы хандлага нь хууль бус гэдгийг тайлбарладаг байх - Дугдугийн талаарх Японы хандлагад бодит тодорхой арга хэмжээ авах - Мэдээлэл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх - PPT ашиглах чадвараа сайжруулах - Та үзэл бодлоо логиктой илэрхийлэх чадварыг хөгжүүлэх
Хандлага	<ul style="list-style-type: none"> - Хятад, Японы түүхийн гажуудлыг шүүмжлэх - Багаар хамтарч ажиллах чадвартай болох

БНСУ-ын Асуудалд суурилсан суралцахуйн туршлагад түшиглэн түүхийн хичээлийн сургалтын арга зүйг сайжруулах судалгаа: Шашны нийгмийн үүрэг хичээлийн сэдвээр

2011 онд асуудалд суурилсан суралцахуйн аргаар хичээлийн төлөвлөгөөг зохиож, Солонгосын ахлах сургуулийн түүхийн хичээл дээр туршилтийн судалгаа хийсэн Пак Мин Со-гийн судалгааны ажил дээр түшиглэн асуудалд суурилсан суралцахуйн сургалтын аргаар Монголын түүхийн хичээлийг заах жишиг загвар, хичээлийн төлөвлөгөөг “Шашин шүтлэгийн нийгмийн үүрэг” сэдвээр энэхүү судалгааны ажилд хийсэн болно.

Хичээлийн зорилгыг тодорхойлох. ЕБС-ийн сургалтад сурагчдын үзэл бодол, сэтгэлгээний эерэг хандлага төлөвшил, хүмүүнлэг энэрэнгүй ёс суртахуун, дадал чадварыг эзэмшүүлэхийг чухалчилж, 1-р ангиас иргэний ёс зүйн боловсрол, 6-р ангиас түүх, 7-

р ангиас нийгэм судлал гэсэн хичээлүүдийг ордог. Эдгээр хичээлд шашны талаарх сэдэв ойлголтууд ихээхэн туссан. Тиймээс “Шашны нийгмийн үүрэг” сэдвээр Асуудалд суурилсан суралцахуйн аргаар түүхийн хичээлийн төлөвлөгөөний жишиг загварыг хийж, турших судалгааны ажлыг эхлүүлсэн. Нэгдүгээрт уг хичээлийн суралцахуйн зорилгыг тодорхойлох зорилго тавьсан. Суралцахуйн зорилго нь танин мэдэхүй, ур чадвар, хандлага гэсэн 3 хэсгээс бүрдсэн(Хүснэгт 2-ийг харна уу).

Хүснэгт 2. Суралцахуйн зорилго

Танин мэдэхүй	<ul style="list-style-type: none"> - Шашны нийгмийн үүрэг гэж юу болох талаар мэдэх - Монгол дахь шашны нийгэмд гүйцэтгэсэн үүргийг мэдэх - Монгол дахь шашны нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг үзэгдлийг баримтаар нотлох
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> - Монгол дахь шашны гаж урсгалын хууль бус гэдгийг тайлбарладаг байх - Гаж урсгалд автахгүйн тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах - Шашин шүтлэгийн шинэчлэл хийх хэрэгтэйг мэдээлэл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийж, бусдад таниулах - PPT ашиглах чадвараа сайжруулах - Сурагчдын үзэл бодлоо логиктой илэрхийлэх чадварыг хөгжүүлэх
Хандлага	<ul style="list-style-type: none"> - Шашны гаж урсгал, сөрөг үзэгдлийг шүүмжлэх - Шашны эерэг чиг хандлагыг өөрийн амьдралдаа мөрдлөг болгох - Багаар хамтарч ажиллах чадвартай болох

Судлаачийн боловсруулснаар

Хичээлийн сэдэлжүүлэлт

Асуудалд суурилсан суралцахуйн арга нь янз бүрийн мэдлэг мэдээллээс тухайн нөхцөл байдалд тохирох хүчин зүйлсийг сонгож, олон төрлийн асуудлаар баяжуулах, асуудлын гол учир шалтгааныг ухаж ойлгоход өөрт байгаа бүхий л нөөц боломжоо дайчлах шаардлагатай болдог. Ингэхийн тулд хичээлийн сэдэлжүүлэлт маш чухал. Жишээ нь: шашин гэдэг ерөнхий ойлголтыг ярьж, сурах бичиг дээр байх хэдэн

тодорхойлолтыг цээжлүүлэх, бясалгал сайхан сэтгэлийн талаар зохион бичлэг бичүүлэх төдийд сургалтын үйл ажиллагааг хязгаарлавал сурагч шашны нийгэмд болон өөрийнх нь амьдралд гүйцэтгэх үүрэг, шашны эерэг болон сөрөг үр нөлөөний талаар, мэдлэг чадвар эзэмшиж чадахгүй. Тийм ч учраас хичээлийн сэджүүлэлтийг сайжруулахын тулд хичээлийн төлөвлөгөөнд сурагчидад өгөх сургалтын эх сурвалж, мэдээллийг дэлгэрэнгүй оруулж өгөх ёстой (хүснэгт 4-ыг харна уу).

Хүснэгт 3. Шашны гаж урсгалд гишгэх мөр байхгүй!

Хичээл	Нийслэлийн Хөгжил цогцолбор сургуулийн 7-р анги
Сэдэв	Шашны гаж урсгалд гишгэх мөр байхгүй!
Холбогдох салбар	Эх түүх, нийгэм судлал, иргэний ёс зүйн боловсрол
Суралцахуйн зорилт	<ul style="list-style-type: none"> - Шашны гаж урсгал, сөрөг үзэгдлийг шүүмжлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах - Шашны эерэг чиг хандлагыг өөрийн амьдралдаа мөрдлөг болгох

Гол агуулга	<p>Миний найз “Гадаад хэл, хувь хүний хөгжлийн үнэгүй сургалт хичээллэж байгаа. Зүгээр л сонирхоод үзээрэй” гэсэн нүдэнд дулаахан хүмүүс, хүний эмзэг талыг мэдэрч сайн ах, эгч, найзын дүрд тоглоон “хайр энэрэл, өгөөмөр сэтгэл, магтаалын үгээр бөмбөгдөж, үнэгүй цай, кофе, хоолонд урьж, аялал зугаалгад хамт явахыг санал болгоно... Эхний сургалтууд нь үнэхээр сонирхол татахаар, дахин дахин очмоор... Тэр сургалтанд үе тэнгийн охид хөвгүүд олон.Тэдний нэг нь миний найз. Найзтайгаа 8 сарын дараа уулзлаа. Царай алдаж, тураад, үс гэгээг тайрчихсан, танигдахын аргагүй хачин болчихсон байсан. Утсаар нэг ярихдаа “Сургалтад сууж байгаа” гэдэг байсан. Тэр үед ийм айтгар зүйл гэж бодоогүй тул олон юм асууж шалгаагагүй. Уулзаад, тийм хачин болчихсон байхаар нь яав, ийв, ямар учиртай сургалт вэ гэтэл “Сүнсэн биеэрээ холбогдсон гэр бүлтэй болсон. 144 мянган хүний тоонд багтаж, бурхны авралд орно, бидний энэ амьдрал бол түр зуурын зовлон төдий, мөнх амьдарна, хэдэн зуу насална, би гэрээслэлээ бичихсэн байгаа” гэсэн юм ярьсан. Бид чинь дөнгөж л 16 настай шүү дээ.</p> <p>Баримт 1. Сонгинохайрхан дүүргийн нутаг, Хархорин худалдааны захын хойд талд байрладаг 29 дүгээр байранд өсвөр насны хүүхдүүд амиа хорлосон харамсалтай хэрэг гарчээ. 14-15 настай хоёр охин тус байрны 12 дугаар давхарт амиа хорлосон байдалтайгаар цогцос нь олдсон байна. Охид амиа хорлохдоо гэрээслэл бичиж үлдээсэн. 2016.03.27</p> <p>Баримт 2. Эрдэнэт хотод өчигдөр өсвөр насны хоёр охин гэрээслэл бичээд, амиа хорлохоор орон сууцны дээрвэс үсэрчээ. Нэг нь эмнэлэгт хүргэгдээд 16.00 цагийн орчимд амьсгал хураасан. Харин үлдсэн охины амийг аврахаар эмч нар шаардлагатай гэсэн эмчилгээг яаралтай хийж байна. 2017.08.16</p> <p>Баримт 3. Хан-Уул дүүргийн нутаг, Зайсан орчмын "Tush one" хотхоноос хоёр охин үсэрч амиа алдсан харамсалтай хэрэг гарчээ. Тодруулбал хэрэг өчигдөр оройн 21:00 цагийн үед гарсан байна. Охид орчны цонхоор үсэрсэн аж. Эх сурвалжийн хэлж буйгаар амиа алдсан охид 16 настай гэв.2017.04.09</p> <p><i>Таны найз Монголд үйл ажиллагаа явуулдаг шашины гаж урсгалын золиос болжээ. Түүний амь насыг та аврах үүрэгтэй. Та бодит байдлыг найддаа ойлгуулж, асуудлыг даван туулахын тулд төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Та ямар төлөвлөгөө бичих вэ? Төлөвлөгөө дараах нөхцөлийг хангасан байх ёстой.</i></p> <p>Анхаарах ёстой нөхцөлүүд</p> <ol style="list-style-type: none"> 1. Төлөвлөгөөг PowerPoint дээр (5 мин) бичсэн байх ёстой. 2. Шашины нийгэмд гүйцэтгэх үүрэг ямар байх ёстойг тусгах 3. Шашины гаж урсгалаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар баримтлах журам зохиох 4. Монгол дахь шашины сөрөг чиг хандлагыг дүгнэх (баримттай)
Агуулгыг илэрхийлэх арга	Текст болон PPT

Судлаачийн боловсруулнаар

Сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг сонгох.

Асуудлыг боловсруулж сэдэлжүүлсний дараа сургалтын материал, хэрэглэгдэхүүнд онцгой анхаарах хэрэгтэй. Сурагчид сонгосон сэдвийн хүрээнд асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүнийг санал болгох нь чухал. Энэ нь асуудлыг шийдэхэд шаардагдах цагийг хэмнэх зорилготой бөгөөд багш нь төлөвлөгдөөгүй сургалтын зорилго руу хазайхаас зайлсхийхэд тусалдаг. Асуудалд суурилсан суралцахуйн арга нь асуудлыг шийдэхэд шууд зөв хариулт өгөхөөс илүүтэйгээр асуудлыг шийдэх зөвлөмжийг өгдөг онцлогтой. Үүгээрээ уламжлалт багш төвтэй сургалтаас зайлсхийх хандлагатай байдаг. Сурагч мэдээ мэдээллээ цуглуулж, дүн шинжилгээ хийх, илтгэл тайлан тавихын тулд өөрт байгаа өөрт байгаа техник технологи, сэтгэн бодох, уншиж бичих, мэтгэлцэх, багаар ажиллах, эрэл хайгуул хийх зэрэг олон чадварыг эзэмших шаардлага тавигддаг (хүснэгт 4-ийг харна уу).

Хүснэгт 4. Сургалтын материал, хэрэглэгдэхүүн

Сургалтын нөөц	Шашины гаж урсгалд гишгэх мөр байхгүй!
Ном зохиол	ЕБС-ийн түүх, нийгэм судлалын хичээлийн сурах бичиг “Ёс суртахууны боловсрол” Г.Дарьхүү, М.Золзаяа, Д.Оюунгэрэл Гантуяа.М , Дагвадорж.Д , Жамбал.А “Шашины судлал” 2019 он.
Интернет сайт	https://dnp.mn Өдрийн сонин. “Аль нь үндэсний шашин бэ?” https://livetv.mn/p/163086 “БНСУ-д коронавирүс тараасан Шинчонжи урсгал Монголд аюул тарихад ойрхон байна” https://ikon.mn/n/14am “Шашины гаж урсгалын гишүүдээ нөлөөлөх арга, түүнээс сэрэмжлэх нь” https://www.montsame.mn/mn/read/218675 “Буддын шашин хамгийн олон ламтай, христийн шашин хамгийн олон сүмтэй” https://youtu.be/D6aZDaEMzOo “Geshe Lhakdor – Is Buddhism Unique?” монгол хадмалтай.

https://youtu.be/Mu_cPjDij0o 신천지 몽골에도 있다! Монгол хадмалтай. https://youtu.be/rKxNs99XYlQ "Хожмын үеийн гэгээнтнүүд: Бид шашныхаа төлөө амиа өгнө" https://youtu.be/kSIbahNSXz4 Вирус нэвтрүүлэг - Монгол дахь Христийн шашны гаж урсгал "Шинэ тэнгэр газар" 1, 2-р хэсэг

Судлаачийн боловсруулснаар

Сургалтын материал хэрэглэгдэхүүнд интернэт сайтад тавигдсан бичлэг, нэвтрүүлэг, эрдэм шинжилгээний өгүүллэг, ярилцлагыг голчилон орууллаа. Энэ нь корона вирусийн тархалтаас болж хөл хорьсон учраас, гэртээ интернэт ашиглан сургалтын үйл ажиллагаа явуулахад дөхөм боллоо.

Үнэлгээний аргачлал боловсруулах

Асуудалд суурилсан суралцахуйн аргын хувьд үнэлгээг "суралцагч төвтэй", "шийдвэрийг үнэлэх", "үнэлгээг төрөлжүүлэх" зарчимд үндэслэсэн байх ёстой. Асуудалд суурилсан суралцахуй нь суралцагчдын төвлөрсөн, өөртөө чиглэсэн сурах орчин тул сурагчдын оролцоог үнэлэхэд онцолсон. Үнэлгээг багшийн үнэлгээ, сурагчийн үнэлгээ, хувь хүний үнэлгээ, төрөлжсөн үнэлгээ зэрэгт хуваасан. Үнэлгээнд сурагчдын бие даах чадвар, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл цуглуулах дүн шинжилгээ хийх, илтгэх, багаар ажиллах, PPT бэлтгэх, унших бичих зэрэг олон чадварыг тусгаж өгөхийг хичээсэн. Мөн сурагчдын өөрийгөө үнэлэх үнэлгээ, сурагчдын бусдыг үнэлэх үнэлгээг илүү нухацтай авч үзэхийн тулд гүйцэтгэлийн үнэлгээтэй харьцуулж үзсэн(хүснэгт 5-6 харна уу).

Хүснэгт 5. Хичээлийн гүйцэтгэлийн үнэлгээний нарийвчилсан төлөвлөгөө

Төрөл ба агуулга	Харьцуулалт	Үнэлгээний арга	Шалгалт авах хугацаа	Хэвээ авах
Бүлгийн үйл ажиллагаагаар дамжуулан Асуудлыг шийдвэрлэх (PBL)	12% 40 оноо	Багийн илтгэл болон тэмдэглэл хөтөлсөн бүх гишүүдийг үнэлгээ	200 мин	6-р сард
Хамрах хүрээ, агуулга	9% 80 оноо	1-р эсээ	80 мин	1-дэх шалгалт
Хамрах хүрээ, агуулга	9% 80 оноо	2-р эсээ	80 мин	2-дах шалгалт

Судлаачийн боловсруулснаар

Хүснэгт 6. Гүйцэтгэлийн үнэлгээний стандарт

Үнэлгээний хэсэг	Үнэлгээний хүчин зүйл (оноо дээр үндэслэсэн)	Оноо (40 оноо)
Багийн үнэлгээ (25 оноо)	Оюутны үнэлгээ (10 оноо)	Сурагчид тус бүрт өгсөн "E-PBL Үнэлгээний хуудас" дээрх үнэлгээний оноог нэгтгэж, дунджаар үнэлнэ.
	Багшийн үнэлгээ (10 оноо)	1. Сэдэв PowerPoint агуулгатай тохирох уу?
		2. Баг бүрт тодорхой, боломжтой шийдлийг гаргаж өгсөн үү?
3. Илтгэгчид ба багийн гишүүд асуултанд зохих ёсоор хариулсан уу?		
4. Тухайн илтгэл цагтаа амжсан эсэх		
Төслийн гүйцэтгэлийн	5. Та бусад багуудыг сонсоходоо зөв хандлагыг харуулсан уу?	Зүйл тус бүрт дээд тал нь 2 оноо, доод тал нь 1 оноо авна. Гэхдээ илтгэл хийгээгүй бол үүнийг 0 цэг гэж үзнэ.
	2. Таамаглал / шийдлийг дарааллаар нь бичсэн үү?	бүрэн байвал 5 оноо авсан 2 байвал 4 оноо 1 байвал 3 оноо

		3. Өөрийнхөө мэдсэн зүйл, илүү ихийг мэдэхийн хүссэн зүйлээ бичсэн эсэх	
		Оноо	25 оноо
Хувь хүний үнэлгээ (15 оноо)	Эргэцүүлэн бодох чадвар (10 оноо)	1. Тохиолдсон өөрчлөлтүүдийг логикоор тайлбарласан уу?	5 төрлийн шаардлагыг бүрэн хангасан бол тус бүр 2 оноо, гүйцэг биш хариулсан бол 1 оноо, огт хийгээгүй бол 0 оноо
		2. Сургалтын үйл явцад шаардлагатай сайжруулалтыг нарийвчлан, логикоор тайлбарласан уу?	
		3. Энгийн сургалт болон e-PBL – сургалтын ялгааг логикоор тайлбарласан уу?	
		4. Та PBL сурах нь бодит амьдралд ямар үр дүнтэйг логикоор тайлбарласан уу?	
		5. Асуудлыг шийдвэрлэх өөр хувилбар эсвэл илүү сайн чиглэлийг санал болгох уу?	
Сурагчийн үнэлгээ (5 оноо)		1. Багт идэвхтэй оролцсон уу?	Сурагч бүрт өгсөн <E-PBL хувийн үнэлгээний маягт> багийн гишүүдийн
		2. Судалгааны үйл ажиллагаа болон асуудлыг шийдвэрлэх явцад та бүлэгтэй сайн хамтарч ажилласан уу?	
		Оноо	15 оноо

Судлаачийн боловсруулнаар

Ээлжит хичээлийн төлөвлөлт

Ээлжит хичээлийн төлөвлөлт гаргахдаа “Асуудалд суурилсан суралцахуйн аргаар Солонгосын ахлах сургуулийн түүхийн сургалтын загварыг зохиож туршилтын судалгаа хийсэн Пак Мин Сонгийн загварыг ашигласан

Хүснэгт 6. Ээлжит хичээлийн төлөвлөлт

Огноо: 2020...	Байршил: Цахим сургалт	Хариуцсан багш: Г.Домбормаа			
Хичээл: Түүх	Анги: 7в, 7г ангийн түүвэр	Заах арга: Асуудалд суурилсан суралцахуй			
Сэдэв: Шашины гаж урсгалд гишгэх мөр байхгүй!		Орчин, хэрэглэгдэхүүн: Интернет, PPT слайд			
Суралцахуйн зорилт: Шашины гаж урсгал, сөрөг үзэгдлийг шүүмжлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах Шашины эерэг чиг хандлагыг өөрийн амьдралдаа мөрдлөг болгох					
Үе шат	Хугацаа(м)	Багшийн чиглүүлэг	Сурагчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн	Үнэлгээ
Шинжлэн судлах, баримт мэдээлэл хайх цуглуулах (Мэдлэг)	2м 7м 5м 8м 3м	Мэндлэх, ирд баталгаажуулах Сэдэлжүүлэлт Шашины үүсэл, хөгжлийн тухай ажлын хуудсыг ажиллуулах Монгол дахь шашин шүтлэг ажлын хуудсыг ажиллуулах Шашины гаж урсгал Монголд үйл ажиллагаа явуулдаг талаар видео үзэх	Сэдэлжүүлэлтийн баримт мэдээлэлтэй танилцах Ажлын хуудас 1, 2, 3-г уншиж, тэмдэглэл хийх	Ажлын хуудас 1, 2, 3 https://youtu.be/kSibahNSXz4	Шалгуурт суурилсан үнэлгээ
Баримт мэдээллийг залдан шинжлэх нэгтгэн нотлох үнэлэх (Чадвар)	20м	Бие дааж судлахаар өгсөн материал, хэрэглэгдэхүүнүүд Сэдэлжүүлэлт болон Ажлын хуудас 1, 2, 3 https://youtu.be/kSibahNSXz4 бичлэгтэй хэрхэн холбогдож байгаа талаар харьцуулалт, дүн шинжилгээ хийлгэх	Сурагчид харьцуулалт, дүн шинжилгээ хийнэ. А.Шашины үүсэл хөгжлийн хүснэгт зохионо. Б.Монгол дахь шашин шүтлэгийн харьцуулалт графикээр хийнэ.	Ажлын хуудас 4,5	Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ

Дүгнэх үнэлэх (Хандлага)	12 м	Бие даалтын талаар санал солилцох	Сэдэлүүлэлтийн бие даалтыг РРТ хэлбэрээр бэлдсэнээ танилцуулж.	Ажлын хуудас 6 Санамжийг ханын сонин болгох	Үр дүнд суурилсан үнэлгээ
	10 м	Хэлэлцүүлгийг чиглүүлэх			
	7 м	Мөрдлөг гаргахад зөвлөх			
Гэрийн даалгавар	5-6 мин	“Шашны нийгэмд гүйцэтгэх үүрэг” илтгэл бичих (3м). Илтгэл бичих зааврын дагуу “Асуудалд суурилсан суралцахуйн аргаар явуулсан хичээлийн талаарх миний бодол” 80 үгтэй. Зохион бичлэг бичих. Зохион бичлэгээ подкастаар оруулах.			

Судлаачийн боловсруулснаар

ДҮГНЭЛТ

Манай оронд шашины сайн үр нөлөөнөөс гадна сөрөг үр нөлөө газар авч олон нийтийн санаа бодлыг түгшээх болсон энэ үед шашины сөрөг нөлөөнөөс өсвөр насны залуучуудыг яаж хамгаалах вэ гэдэг асуудал чухлаар тавигдаж байна. Тиймээс энэхүү судалгаанд түүхийн хичээлийн сургалтын арга зүй, үр дүнг сайжруулах замаар шашин шүтлэгийн сөрөг нөлөөллөөс өөрийгөө хамгаалах мэдлэг, ур чадвар, хандлагыг өсвөр насны хүүхдүүдэд төлөвшүүлэх боломжийг судлах зорилго тавин ажилласан.

Судалгааны ажлын явцад түүхийн боловсролоор дамжуулан нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд асуудалд суурилсан суралцахуйн аргаар түүхийн хичээлийн сургалтын үр нөлөөг дээшлүүлсэн БНСУ-ын судлаачдын туршлагыг Монгол Улсын ЕБС-ийн сургуулийн сургалтын онцлогт тохируулан нутагшуулахад илүү үр өгөөжтэй болох нь ажиглагдсан.

Судалгааны ажлын үр дүнд уг Солонгосын судлаачдын

туршлагад түшиглэн асуудалд суурилсан суралцахуйн сургалтын аргаар Монголын түүхийн хичээлийг заах жишиг загварыг шашин шүтлэгийн нийгмийн үүрэг сэдвээр боловсруулж гаргасан.

Асуудалд суурилсан суралцахуйн арга зүйд тулгуурлан зохиосон түүхийн хичээлийн жишиг төлөвлөгөө загварыг Монголын түүхийн хичээл дээр цахим хэлбэрээр туршсан. Судалгаанд оролцсон суралцагчдын идэвх оролцоо сайжирч, мэдээ мэдээлэл цуглуулах, түүнийг боловсруулж дүн шинжилгээ хийх, илтгэл бичих, РРТ танилцуулга бэлдэх, төлөвлөгөө боловсруулах чадварт богино хугацаанд суралцаж байгаа нь ажиглагдсан. Ганцаарчилсан болон багаар ажиллах, бусдыг болон өөрийгөө үнэлж дүгнэх арга барил эзэмшиж байна. Түүх нийгмийн үзэгдэлд үнэлэлт дүгнэлт өгөх, үзэл бодлоо шинжлэх ухаанч байр сууринаас зөв боловсон илэрхийлэх үр дүн харагдлаа. Өмнө нь хүүхэд өөрийгөө нээж чадахгүй, бусдад таниулж чадаагүйгээсээ болж тааруу үнэлгээ авдаг байсан бол энэхүү сургалтын аргыг ашигласнаар сурагч техник технологи ашиглан илтгэл тавьж, мэтгэлцээнд идэвхтэй оролцож, бага багаар өөрийгөө нээж байгаа нь ажиглагдсан бөгөөд энэ нь асуудалд суурилсан суралцахуйн үр дүн байлаа Энэхүү аргаар сургалт явуулахад багшийн зүгээс хичээлийн бэлтгэл ажил,

менежмент их чухал байна. Хичээлийн сэдэлжүүлэлтээс эхлээд сурагчдыг яаж хичээлд нь үр дүнтэй, сонирхолтойгоор оролцуулах тал дээр түлхүү анхаарч байсан. Багш сурагчтайгаа хамт суралцах тохиолдол ч ажиглагдлаа.

Асуудалд суурилсан суралцахуйн аргаар цахим хэлбэрээр түүхийн хичээлийг явуулах нь үр дүнтэй байсан ч сургалтын үйл ажиллагаанд олон төрлийн мэдээ мэдээлэл цуглуулах, түүндээ дүн шинжилгээ хийх, РРТ танилцуулга, илтгэл бичих зэрэг сурагчдад ирэх ачаалал эрс нэмэгдэж байв. Тийм ч учраас ЭЕШ өгдөг ахлах ангийн хичээлд энэхүү аргыг хэрэглэхдээ уян хатан байх шаардлагатай нь ажиглагдлаа. Сурах орчин, интернэт, техник технологи, эцэг эхийн дэмжлэг маш их чухал байна.

Энэхүү судалгаанд бид шашин шүтлэгийн манай орны нийгэмд үзүүлж буй сөрөг талуудыг буруулах, сурагчдын шашин шүтлэгийн нийгмийн үүргийн талаарх мэдлэг, ур чадвар, хандлагыг сайжруулах зорилгоор асуудалд суурилсан суралцахуйн сургалтын аргаар түүхийн хичээлийг заах жишиг загварыг чанарын судалгаан дээр тулгуурлан боловсруулах ажлыг хийсэн. Цаашид бодит сургалтын орчинд асуудалд суурилсан аргаар түүхийн хичээлийг заахад сургалтын үр дүнд, сурагчдын мэдлэг, ур чадвар, хандлагад ямар өөрчлөлт гарахыг

судлах шаардлагатай байна. Магистрын судалгааны ажлаа энэ чиглэлээр хийхээр зорьж ажиллаж байна.

НОМ ЗҮЙ

1. Creel, D. B. (2007). Assessing the influence of religion on health behavior. Indiana University
2. Dow J. W. A (2007) scientific definition of religion. Retrieved from <http://www.anpere.net/2007/2.pdf> date 1-12-2013.
3. Einolf, C. J. (2011). The link between religion and helping others: The role of values, ideas, and language. *Sociology of religion*, 72(4), 435-455.
4. Farmer, M. A., Trapnell, P. D., & Meston, C. M. (2009). The relation between sexual behaviour and religiosity subtypes: A test of the secularization hypothesis. *Archives of Sexual Behavior*, 38(5), 852-865.
5. Smidt, C. (2003). Religion as social capital: producing the common good: Baylor University.
6. “Монгол дахь шашин судлалын асуудлууд” олон улсын эрдэм шинжилгээний илтгэл. С.Дэмбэрэл 2019 он
7. “Монгол Улс дахь шашны төлөв байдал” судлаач Б.Мөнхцацралт. ШУА
8. “Монгол-Төвдийн улс төр шашны харилцааны түүх” (XVI-XVIII зууны эхэн) , Дашбадрах.Д УБ., 1998
9. “Монголын бурхны шашин” зохиолч, төвд судлаач Гленн Муллин.
10. “Түүхийн хичээлийн цөм хөтөлбөр” 2 дахь удаагаа сайжруулсан. 2019 он
11. “Шашны байгууллагын зүгээс нийгмийн хөгжилд оруулах хувь нэмэр, оролцоо” Ж. Алтайбаатар, Б.Бадрах. 2017 он.
12. Бага, дунд боловсролын тухай хууль
13. Боловсролын тухай хууль
14. 박성미 2011 “PBL 에 의한 고등학교 국사과 수업 설계 및 적용 사례 연구”
15. 강숙희, 2008, “중학교 과학교과에서의 실시간 PBL 사이버 수업이 학생들의 자기조절 학습과 학습태도에 미치는 영향” , 교육정보미디어연구.

16. 강인애 정준환 정득년, 2007, “PBL 의 실천적 이해: PBL 수업을 위한 길라잡이”, 문음사
17. 김한중, 2007, “역사수업의 원리”, 책과함께
18. 송상현, 2002, “역사인식의 구성적 성격과 역사교육적 함의” , 서울대박사학위논문.
19. 유지연, 2001, “지식기반사회에서의 e-Learning 현황 및 전망” , “정보통신정책” 13.
20. 이정석, 2006, “PBL 수업에서 학습자로서의 자신에 대한 인식변화에 대한 사례 연구” 경희대학교 교육대학원 석사학위 논문.
21. 최상훈 이영효 김한중 강선주, 2007, “역사교육의 내용과 방법” 책과함께
22. 최정임 장경원, 2010, “PBL 로 수업하기”, 학지사.